

**ХӨДӨЛГҮҮРИЙН ОНОШИЛГООНЫ СУРГАЛТЫН
АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА	
1	Зорилго	Ажилтнуудыг хөдөлгүүрийн оношилгооны чиглэлээр мэргэшүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ.
2	Зорилт	Сургалтын хэрэгцээнд үндэслэн хамрагдах хүрээг хангаж чадахуйц чанартай, ур дүнтэй сургалтыг авах.
3	Хэрэгцээ, шаардлага	Орчин үеийн механизмын хөдөлгүүр камминс хөдөлгүүртэй болж байгаа тул техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрт гарсан эвдрэл, гэмтлийг зөв оношилж сурх.
4	Сэдэв	Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах; <ul style="list-style-type: none"> • ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандарт; • ХАБЭА-н менежмент, системийн тухай; • Сургагч багшийг мэргэшүүлэх, арга зүйн талаарх ойлголт; • Түлшний систем, агаар оруулах, гаргах системийн оношлогоо
5	Хэлбэр	Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах شاардлага	<p><u>Сургалтын байгууллагад:</u></p> <ul style="list-style-type: none"> • Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх; • Тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай; • Сүүлийн 2 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай; • Тухайн чиглэлийн мэргэшсэн, мэргэжлийн туршлагатай багш нартай байх; • Цахим сургалтыг явуулж байсан туршлагатай байх; • Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах; • Сургалтын зориулалтын анги танхим, дадлага хийх тоног төхөөрөмжтэй байх; • Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх, сертификат олгох; <p><u>Сургагч багшид:</u></p> <ul style="list-style-type: none"> • Сургагч багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх; • Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай; • Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалт явуулах; • Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх; • Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.
7	Хамрах хүрээ	“Салбарын Техник ашиглалт, засвар механикийн хэлтсийн ажилтнууд
8	Хугацаа	2021 оны III, IV улиралд зохион байгуулах

		“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах.
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн үнэмлэх /сертификат/ болон бусад зардал
10	Үр дүн	Хөдөлгүүрийн гэмтлийг хурдан оношилсноор дараа дараагийн засварын арга хэмжээг шуурхай авч, ТББ-ыг хангах боломжтой болно.